



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/440

Улаанбаатар хот

Багануур дүүргийн Албан бус насан  
туршийн боловсролын төвийн эргэлтийн  
бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,356,990 (долоон сая гурван зуун тавин зургаан мянга есөн зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Багануур дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв (А.Өсөхжаргал)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 11 нэр төрлийн 2,046,990 (хоёр сая дөчин зургаан мянга есөн зуун ер) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 4 нэр төрлийн 5,310,000 (таван сая гурван зуун арван мянга) төгрөгийн хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 54,000 (тавин дөрвөн мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 16,200 (арван зургаан мянга хоёр зуу) төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Багануур дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв (А.Өсөхжаргал)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс (М.Мандах)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001189



Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2021 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн А/АХО... дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Багнуур дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨАҮГ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХК-н шийдвэр
1	Джитал аппарат	9	Ш	1	430,000.00	430,000.00	430,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
2	Проектор дэлгэцтэй	9	Ш	1	1,100,000.00	1,100,000.00	1,100,000.00	-		актлах	4,000	устгах	4,000
3	Хэвлэгч	9	Ш	1	299,990.00	299,990.00	299,990.00	-		актлах	устгах	устгах	устгах
4	Ариутгагч	10	Ш	1	100,000.00	100,000.00	100,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
5	Лимнаторын индүү	9	Ш	1	65,000.00	65,000.00	65,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
6	Таблет	5	Ш	2	220,000.00	440,000.00	440,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
7	Компьютер	9	Ш	5	740,000.00	3,700,000.00	3,700,000.00	-		актлах	10,000	устгах	10,000
	Машин тоног төхөөрөмжийн дүн				6,134,990.00	6,134,990.00	6,134,990.00	-	ашиглалтын шаардлага хангахгүй		14,000	устгах	14,000
8	Тавиур	10	Ш	3	20,000.00	60,000.00	60,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
9	Тумбочка	10	Ш	2	35,000.00	70,000.00	70,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
10	Гоо сайхны ор	10	Ш	3	120,000.00	360,000.00	360,000.00	-		актлах	устгах	устгах	30,000
11	Гоо сайхны ор	10	Ш	1	150,000.00	150,000.00	150,000.00	-		актлах	устгах	устгах	10,000
12	Компьютерын сандал	10	Ш	5	50,000.00	250,000.00	250,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
13	Тавиур	10	Ш	1	30,000.00	30,000.00	30,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
14	Дрож	5	М	4	60,500.00	242,000.00	242,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
	Тавилга, эд хогшлын дүн				1,162,000.00	1,162,000.00	1,162,000.00	-	ашиглалтын шаардлага хангахгүй				40,000
15	Архивын онлайн программ	8	Ш	1	60,000.00	60,000.00	60,000.00	-		актлах	устгах	устгах	устгах
	Программ хангамжийн дүн				60,000.00	60,000.00	60,000.00	-					
	Нийт данснаас хасах хөрөнгийн дүн				7,356,990.00	7,356,990.00	7,356,990.00	-	-	-			
	Үүнээс: Худалдах хөрөнгө				5,310,000.00	5,310,000.00	5,310,000.00	-	4				
	Актлах хөрөнгө				2,046,990.00	2,046,990.00	2,046,990.00	-	11				
	Худалдсанаас олох орлого							-					54,000.00
	НӨХГ-т төвлөрүүлэх /30%/							-					16,200.00